

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТҮР ШТАБЫН ХУРЛЫН ШИЙДВЭР

2021 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

№ 13

Улаанбаатар хот

Иргэний нисэхийн ерөнхий газрын гамшгаас хамгаалах түр штабын 13 дугаар хурлыг 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минутад цахимаар зохион байгуулав. Тус хуралд ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн, Дэд дарга Б.Алтанцом, Иргэний нисэхийн ерөнхий газрын гамшгаас хамгаалах түр штабын гишүүд болон ИНҮТ-ийн дарга, тус төвийн гамшгаас хамгаалах штабын гишүүд тус тус оролцов.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цагаас эхлэн бууруулж 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах талаар болон үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой бусад асуудлаар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. 2021 оны 5 дугаар сарын 08-ны өдрөөс мөн оны 6 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын 3-р түвшин буюу "Улбар шар" түвшинд шилжихтэй холбогдуулан байгууллагын үйл ажиллагааг тодорхой үе шаттайгаар эхлүүлэхдээ ажлын байрны нягтралыг бууруулах зорилгоор коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалтын 2 тунд бүрэн хамрагдсан ажилтнуудыг ажлын байранд ажиллуулах, дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авч, зохицуулалт хийж, хуваарь гаргаж ажиллахыг бүх газар, харьяа салбар нэгжийн дарга нарт;

2. Ажилтнуудын өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг харгалзан цахимаар зайнаас ажиллуулах боломжоор хангахыг Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газар /П.Ариунболд/-т, Иргэний нисэхийн үндэсний төв /П.Мөнхжаргал/-д;

3. УОК-ын 2021 оны 17 дугаар хуралдааны шийдвэрийн 2.3-т заасны дагуу ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжийн вакцинд хамрагдаагүй ажилтнуудыг 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор вакцины 1-р тунд хамруулах, вакцины 2-р тунд хамрагдах ажилтнуудыг мөн оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн хамруулахыг бүх газар, салбар, нэгжийн дарга нарт;

4. "Буянт-Ухаа" ОУНБ болон Орон нутгийн нисэх буудлуудын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангуулахыг Иргэний нисэхийн үндэсний төв /П.Мөнхжаргал/-д;

5. Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 41 дүгээр тушаалаар батлагдсан "Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ын хэрэгжилтийг ханган ажлын байранд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах, мэргэжлийн байгууллагаас

гаргасан заавар, зөвлөмжийн дагуу ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж ажиллахыг бүх газар, салбар, нэгжийн дарга нарт;

6. Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар тушаалаар батлагдсан "Коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх түр журам" болон "Байгууллагын зүгээс /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөл хорионы үед ажилтны бэлэн байдал, ар гэрийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж"-ийг нийт ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтийг хангах, холбогдох судалгааг гаргах, журам боловсруулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газар /П.Ариунболд/-т, Иргэний нисэхийн үндэсний төв /П.Мөнхжаргал/-д тус тус даалгав.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТҮР ШТАБЫН ДАРГА БӨГӨӨД
АННББЗГ-ЫН ДАРГА Д.ЭРДЭНЭБААТАР

